



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/46

Сангиндалай

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт Зэгэстий нэртэй өвөлжөөний зориулалттай газрыг эзэмшигч иргэн Жамганбазарын Мөнхжаргал (ЗЮ68011107)-ын газрыг 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 49 тоот газар эзэмших гэрээгээр Гочоогийн Мандах (ЗП7101515)-д газрыг зориулалтаар нь 7 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэний газрын бичиг баримтыг хуулийн дагуу бүрдүүлж, газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон ажиллахыг газрын даамал (Э. Ууганцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/02 дугаар тоот захирамжийн Ж.Мөнхжаргалд холбогдох заалтыг, Газар эзэмших эрхийн 0000152780 дугаар гэрчилгээг тус тус хүчингүй болгосонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



О.БАЗАРРАГЧАА

482302091